***Агуулгын жагсаалт:***


1.Үндэслэл ..... 3
2.Төслийн товч танилцуулга ..... 4
2.1. Төслийн  танилцуулга ..... 4
2.2.Төслийн байршил: ..... 4
2.3.төслийн ерөнхий төлөвлөгөө ..... 6
2.4.Төслийн хүчин чадал, төлөвлөлтийн үндсэн үзүүлэлт ..... 7
2.5.Үндсэн  түүхий эд, туслах материал ..... 14
2.6.Дэд бүтэц: ..... 14
2.6.1.Зам харилцаа: ..... 14
2.6.2.Цахилгаан хангамж: ..... 14
2.6.3.Дулаан хангамж ..... 14
2.6.4.Усан хангамж: ..... 17
3.Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт ..... 19
3.1.Төсөл хэрэгжих талбайн орчны хөрсөн бүрхэвч, түүний онцлог: ..... 20
3.2.Агаарын чанарын өнөөгийн байдал: ..... 21
3.3.Төслийн талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдал: ..... 21
3.4.Тусгай хамгаалалттай газар нутаг: ..... 22
3.5.Нийгмийн суурь нөхцөл: ..... 23
4.Төслийн үндсэн ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт ..... 24
4.1.2026 онд гүйцэтгэх  ажлын төлөвлөгөө ..... 24
4.2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл ..... 24
4.3.Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл ..... 25
4.4.Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөлөл ..... 26
4.5.Газар доорх усанд үзүүлэх нөлөөлөл ..... 26
4.6.ТХГН, түүх, соёлын дурсгалт зүйлст учруулж болзошгүй нөлөөлөл ..... 27
4.7.Нийгэм, хүн амд нөлөөлөх нөлөөлөл ..... 27
4.8.Хог хаягдал ..... 27
5.Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө түүний гол зорилт ..... 28
6.Агаар  орчинд үзүүлэх сөрөг  нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 30
6.1.Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх  нөлөөллийг  бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 32
7.Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө ..... 40
8.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ..... 41
9.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн  олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө ..... 41
10.Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө ..... 41
11.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ..... 42
12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ..... 46
12.1.Ерөнхий зүйл: ..... 46
12.2.Барилгын хог хаягдал ..... 46
**12.3.Хог хаягдлыг зайлуулах арга зам ..... 46**
13.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн аргачлал, арга зүй ..... 49
13.1.Орчны хяналт, шинжилгээний  хөтөлбөрийн зардал ..... 49

14.2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө...... 52

15.2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө ...... 54

# 1.ҮНДЭСЛЭЛ

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо, Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлах "Ланд энд Хаус" ХХК-ийн "Аялал жуулчлалын цогцолбор хотхон" төсөл хэрэгжинэ.

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо, Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлах "Ланд энд Хаус" ХХК-ийн "Аялал жуулчлалын цогцолбор хотхон" төслийн баримт бичигт "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгэний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын батлагдсан "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-ийг тус тус үндэслэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтээр баталсан БОННҮ-ний 5 жилд хэрэгжүүлэх нийт төсвийн БОМТ-ний **2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ** боловсруулав.

БОМТ-г боловсруулахдаа 2019 оны 10-р сарын 29-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах журмыг удирдлага болгов.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ нь БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРӨӨС** бүрдэнэ.Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах зардлыг тусгасан. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүний хэрэгжүүлэх арга зүй, хугацаа, давтамж, шаардагдах зардлыг тусгасан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг 2026 оны 12-р сарын 01-ний дотор Нийслэлийн Байгаль Орчны Газарт ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг журмын дагуу зохион байгуулах шаардлагатай.

# 2.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 2.1. Төслийн танилцуулга

| | |
|---|---|
| *Төсөл хэрэгжүүлэгч* | **“ЛАНД ЭНД ХАУС” ХХК**<br>➢ Улсын бүртгэлийн дугаар:9011392048<br>➢ Регистрийн дугаар: 2661284 |
| *Байгууллагын хаяг:* | ➢ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Парисын гудамж, 42-р барилга, 1101 тоот *Утас:* 75075454 |
| *Ерөнхий үнэлгээний дүгнэлт* | ➢ БОАЖЯ-ны 2024 онд 06 дугаар сарын 26-ны өдрийн 12/3115 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлт |
| *Зураг төсөл боловсруулах үндэслэл:* | ➢ Баянзүрх дүүргийн 11 -р хороо, Хүрэлтогоотын ам Нийслэлийн Ерөнхий Архитектор батлагдсан “Ланл энд хаус” ХХК-ийн “Аялал жуулчлалын цогцолбор” зурагтай |
| *Барилга байгууламжийн байршил:* | ➢ Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 11-р хороо |
| *Төслийн хүчин чадал:* | ➢ “Аялал жуулчлалын цогцолбор хотхон” төсөл нь жилийн 4 улиралд тасралтгүй үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөсөн ба хоногт 200-250 хүн хүлээн авах хүчин чадалтай. Тус хотхонд нийт 30 хүн байнга ажиллана. |

### *2.2.Төслийн байршил:*

Судалгааны талбай нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо, Хүрэлтогоотын аманд байрзүйн зургийн L-48-10 хавтгайд Туул голын сав газарт хамааран байрлаж байна.

***Зураг 1. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн зураг***



***Төслийн зорилго;***

- Улаанбаатар хотын болон гадаадын жуулчдын аялж амрах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах
- Улаанбаатар хотын агаарын бохирдлоос хамгийн ойр зайд байрлах цэвэр агаар бүхий ногоон байгууламжаар хүрээлэгдсэн тохилог, тухтай орчинд гэр бүл, найз нөхөд, дотны хүмүүстэйгээ цагийг өнгөрөөх боломж бий болгох
- Үзэсгэлэнт байгалийг түшиглэн тохь тухтай, соёлтой үйлчилгээ бүхий өндөр зэрэглэлийн амралтын газар байгуулах
- Байгалийн сайханд түшиглэсэн ногоон хөгжил хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн байгалийн унаган төрхийг алдагдуулахгүйгээр иргэдийн орлогыг тогтвортойгоор дээшлүүлэн ногоо худалдан авалтыг хийхэд оршино.
- Ажлын байр бий болгох

***Газарзүйн солбицол:***

Аялал жуулчлалын цогцолбор хотхон төсөл нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо, Богдхан уулын ДЦГ, Хүрэлтогоотын аманд Маршалын гүүрнээс Баянзүрхийн товчоо чиглэлийн авто замаас урагш 3 км, Скай ресортоос баруун урагш 1.5 км-ийн зайд байрлах ба 15 га талбайд хэрэгжинэ.




**Хүснэгт 1.Нэгж талбарын 1333110271 дугаартай 150009 м/кв газрын солбицолын цэг**

| д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 107 | 4 | 0.979 | 47 | 52 | 17.275 |
| 2 | 107 | 4 | 6.347 | 47 | 52 | 25.686 |
| 3 | 107 | 3 | 59.218 | 47 | 52 | 33.464 |
| 4 | 107 | 4 | 14.005 | 47 | 52 | 29.341 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | 107 | 4 | 17.261 | 47 | 52 | 28.324 |
| 6 | 107 | 4 | 17.468 | 47 | 52 | 10.986 |

## 2.3.ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Талбайн эзлэх хувь -/%/**

- Барилгажих талбай 3.8 га- 25%
- Инженерийн байгууламж 0.2 га- 1.4%
- Авто зам болон явган хүний зам талбай 1.7 га -11.3%
- Тохижилт ногоон бүс 1.4 га - 9.6%
- Тохижилт, тоглоомын талбай 1.1 га- 7.5%
- Эко ногоон бүс 6.8 га- 45.2%

**Нийт 15.0 га – 100%**



## *2.4.ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ*

Төлөвлөж буй газрын онцлог, байрлал, газрын гадаргын онцлогоос хамаарч хурын ус урсдаг гуу жалгыг түшиглэн хиймэл даланг ил ба далд гэсэн 2 төрлийн хоолой (суваг)-аар урсшаж хурын усыг цэвэршүүлэх болон зөөврийн усыг ашиглан хиймэл нуур үүсгэн байгалийн үзэмжийг улам нэмж, орчны чийгшилийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. 1-р хэсэг буюу ус зайлуулах далангийн зүүн талд бага зэргийн налуутай талбайд /нийт талбайн 60 хувь/ өвөл зуны зориулалттай, дулаан зогсоолтой, хамгийн багадаа 1 сарын хугацаатайгаар тооцогдон буудаллах /түрээслэх/ зориулалттай тансаг зэрэглэлийн 2 давхар байрууд байхаар тооцон төлөвлөсөн. Эдгээр сууцууд нь талбайн хэмжээгээр том, жижиг гэсэн 2 төрлийн төлөвлөлттэй байна. 2-р хэсэг буюу ус зайлуулах далангийн баруун хэсэгт /нийт талбайн 30 хувь/ цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар төлөвлөж байна.

Зочдыг ая тухтай байлгах үүднээс цогцолбор хотхоны орчны тохижилт, ногоон байгууламж, явган зам, дугуйн зам, гэрэлтүүлэг, тоглоомын талбай, залуусын цагаа зөв боловсон өнгөрүүлэх скейт, роллик, сагсан бөмбөг, теннис гэх мэт тохижилтыг төлөвлөснөөс гадна талбайг бүрэн хашаажуулж авто замын сүлжээ, зогсоол харуулын байр, камер, хяналтын системтэй байхаар төлөвлөсөн байна.

- *Амрагчдын байр*
    - 190 м$^2$ – 44 ш
    - 150 м$^2$ – 22 ш
    - 150 м$^2$ – 20 ш
- *Амрагч, түрээслэгчдийн ая тухыг хангах боломжтой үйлчилгээний байр*
- *Ресторан*
- *Авто зогсоол*
- *Амрагч, түрээслэгчдийг идэвхжүүлэх зорилготой үйл ажиллагаа зохион байгуулах*
- *Клубууд (Иога, уулын аялал, морин аялал гм)*
- *Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж*
- *Хүүхдийн тоглоомын талбай*
- *Спорт үйл ажиллагаа явуулах талбай*
- *Мах шарах хэсэг (Grill area)*
- *Тусгай арга хэмжээ зохион байгуулалт*

### 2.4.1.ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА (CLUB HOUSE):

Тансаг зэрэглэлийн Лоунж зоогийн газар (Restaurant & Lounge), VIP тусгай өрөө, жижиг уулзалтын өрөө, халуун усны газар (VIP Sauna, Spa, Massage, Mini pooL), зуны асар зэрэг үйлчилгээний хэсэг, мөн удаан хугацаагаар байрлах зочдын гэр бүлд зориулсан 1-3 нас, 3-6 нас, 7-10 насны ангилалтай өдөр өнжүүлэх, цэцэрлэг буюу хүүхэд харах үйлчилгээний хэсэг, мөн гал тогоо, ажилчдын өрөө, техникийн өрөө бүхий 1000 м$^2$ талбайтай, үндсэн 3, туслах 2 орц гарцтай, 1 давхар барилга байна.

## 2.4.2.АМРАЛТЫН БАЙРУУД:

150 $м^2$ болон 190 $м^2$ талбайтай, 2 давхар, давхар бүрт ариун цэврийн өрөө, мастер болон энгийн унтлагын өрөө, террас, тусдаа дулаан зогсоол, ногоон байгууламжтай байхаар төлөвлөгдсөн. Барилгын гадна талыг шилэн фасад, чулуун фасад, модон хийцлэл зэргийг хослуулан нийцүүлж хийх ба хурын усыг зайлуулах хавтгай дээвэртэй байна. Нийт 86 ш амралтын байр байна.

**Зураг 2.Амралтын байрнуудын  бүтээн байгуулалтын хэсэг**



*Зураг 3.Төслийн ерөнхий төлөвлөлт*




ХАРАГДАХ БАЙДАЛ


ХАРАГДАХ БАЙДАЛ



**Зураг 4.Төслийн барилга байгууламжийн өнөөгийн байдал**



Барилга бүтээн байгуулалтынхаа шатанд явж байгаа байдал

## 2.5.ҮНДСЭН ТҮҮХИЙ ЭД, ТУСЛАХ МАТЕРИАЛ

Барилга угсралтын үндсэн материал болох бетон зуурмаг, хэв хашмал зэрэг материалуудыг дотоодын зах зээлээс хангахаар төлөвлөсөн. Харин усалтын системийн үндсэн тоног төхөөрөмжүүд болох бороожуулах машин, гол болон хуваарилах хоолой, усалгааны хоолой бусад туслах материалуудыг Хятад улсаас импортлон ашиглаж байна.

## 2.6.ДЭД БҮТЭЦ:

### 2.6.1.ЗАМ ХАРИЛЦАА:

Зам харилцааны хувьд Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо, Богдхан уулын ДЦГ, Хүрэлтогоотын аманд Маршалын гүүрнээс Баянзүрхийн товчоо чиглэлийн авто замаас урагш 3 км, Скай ресортоос баруун урагш 1.5 км-ийн зайд байрлалтай.

### 2.6.2.ЦАХИЛГААН ХАНГАМЖ:

Төсөл хэрэгжүүлэгч нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ цахилгааны нэгдсэн сүлжээ буюу "Улаанбаатар цахилгаан түгээх" ХХК-ийн өндөр хүчдэлийн шугамаас 630кВа, 10/0.4 кв трансформатор байгуулан аялал жуулчлалын цогцолборт шаардагдах газрууд руу далд холболтоор хүргэснээр өдөр тутмын цахилгаанаар хангахаар төлөвлөсөн байна. (Түр техникийн нөхцөл дугаар:25/204)

Амралтын байрны доторх цахилгаан холболтыг орос, германы монгол улсын стандарт болон ISO 9002 стандартын шаардлага хангасан техник тоног төхөөрөмжөөр холбож тоноглоно.Зочид хүлээн авах, амрах байрны цахилгаан хангамжийг улирлаас хамаарч 5-10% -ийг сэргээгдэх эрчим хүчээр хангахаар төлөвлөн судалгаа, зураг төсөл хийгдэж байна. Энэ нь урьдчилсан тооцооллоор 2500Вт/өдөр сэргээгдэх эрчим хүч хэрэглэхээр төлөвлөсөн байна.

Хотхоны автозам, зогсоол, биеийн тамир, амралтын талбай, ногоон байгууламжийн гоёлын гэрэлтүүлгийн нийт цахилгааны ачаалал 11.9кВт нарны сэргээгдэх эрчимээр хангахаар тооцоолол судалгаа хийгдсэн байна. Энэ нь жилдээ 4МВт-ийн энергийг сэргээгдэх эрчимээр хангахаар байна.

### 2.6.3.ДУЛААН ХАНГАМЖ

Цахилгаан эрчим хүчээр мөн нарны эрчим хүчээр хангана. Монгол Улс тэр тусмаа Монголын говь хөрсөн доороо арвин их эрдэс баялагтай шигээ агаартаа нар, салхины асар их нөөцийг хадгалсан онцлогтой. Жилийн 250 гаруй хоног нь нартай, цэлмэг байдаг манай улсад нар, салхинаас гадна зарим бүс нутагт усан цахилгаан станц барьж байгуулах бүрэн дүүрэн боломж бий.

**Сэргээгдэх эрчим хүч** гэдэг нь байгаль дээр тасралтгүй нөхөн сэргээгдэж байдаг энерги бөгөөд үүнд нарны эрчим хүч, салхины эрчим хүч, усны эрчим хүч, биомассын эрчим хүч, далайн татралт, түрэлтийн эрчим хүч, газрын гүний дулааны эрчим багтдаг. 2005-2006





оны байдлаар Дэлхий дээр үйлдвэрлэсэн нийт эрчим хүчний 18%-ийг сэргээгдэх эрчим хүчнээс гарган авсан байна.Үүний 13%-ийг уламжлалт түлш болох модноос, 3%-ийг уснаас (Дэлхийн цахилгаан эрчим хүчний 15%), 1.3%-ийг нарны эрчим хүчнээс (*solar hot water* - нарны дулаанаар усыг халаан хэрэглэх), үлдэх 0.8% орчмыг нь газрын гүний дулаан, салхи, нар, далайн эрчим хүчийг ашиглан гарган авч байна.




Зураг 5.Бороо шороонoос хамгаалсан нараар ажилладаг сүүн гэрэл сонгголтууд










SOLAR LIGHTS
Нарны мэдрэгчтэй гэрэл
1. Эрчим хүчний хэмнэлттэй
2. Нарны энергиэр ажилладаг
3. Бороо шороо тоосны хамгаалалттай
4. Асалтын 2 өөр тохиргоотой (тод, бүүдэг)
Хэмжээ: 16x12см
Асалтын өнгө: цагаан
Үнэ:30,000


SOLAR LIGHTS
Явган замын жижиг LAWN гэрэл
1. Эрчим хүчний хэмнэлттэй
2. Хоёр горимтой (нараар + тогоор)
3. Суурилуулахад хялбар
Зөөвөрлөх мөн байрлалуулахад амар
4. Байгальд ээлтэй
Хэмжээ: 25x15.5 см
Асалтын өнгө: шар
Үнэ:45,000


SOLAR LIGHTS
Нараар ажилладаг шонгийн гэрэл
1. Эрчим хүчний хэмнэлттэй
2. Нарны энергиэр ажилладаг
3. Бороо шороо тоосны хамгаалалттай
4. 150W хүчин чадалтай
Хэмжээ: 60x22,5см
Асалтын өнгө: цагаан.
Үнэ: 75,000


ХАЛААЛТЫН ХЭСЭГ
ХЭСЭГЛЭЛ-1
ХЭСЭГЛЭЛ-2
Ус цэвэршүүлэгч төхөөрөмж
Дулааны тоолуур Ф100
Ф150
Ф125
Ф65
+ 3.20
+ 3.00
+ 3.30
+ 2.30
+ 1.30
+ 1.15
+ 0.45
Grundfos CRS-11
Grundfos TP80-335/2
Тэлэлтийн сав 750Л
Халаалтын системийн ялтсан ус халаагуур
Температур тохируулах автомат хаалт
Ялтсан ус халаагуур 0.94MBт
Ус буцаах хаалт
Насосны бүү намсгагч
Зөвшөөрөлцсөн
БА
ББ
ХАС
ЦБУ
ХТ/ДГ
ХД/ГА
"ТДХ" ХХК
Халаалтын хэсэг
А3
М.Манхзаян
П.Цэрэнжаргал
ЗЭП-09/25
ТДХ-052/2025
М1:50
ДМ-8
132

### 2.6.4.УСАН ХАНГАМЖ:

Төсөл хэрэгжүүлэгч "Ланд энд хаус" ХХК нь УСУГ-ын Техникийн нөхцөл олгох комиссын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрээр олгосон техникийн нөхцөлийн дагуу Улаанбаатар хотын төвийн цэвэр усны Ф800 мм-ийн шугамын худгаас шинээр салбар шугам татан цэвэр усны хэрэглээгээ хангахаар төлөвлөсөн байна.




**308/24 тоот техникийн нөхцлийн схем зураг**



ТАНИХ ТЭМДЭГ

- Шугам сүлжээнд холбогдох барилга
- Цэвэр усны шугам
- Цэвэр усны худаг
- Бохир усны шугам
- Бохир усны худаг

ТОДОРХОЙЛОЛТ

| | |
|---|---|
| 1 | Төлөвлөж буй байршил |
| 2 | "Скай ресорт" цогцолбор |
| 3 | Орчны барилгууд |
| 4 | Авто зам, талбай |

Ус Сувгийн Удирдах Газрын 802 тоот Утас: 70157018- 182, website: http//usug.mn

УСУГ-ЫН ТЕХНИКИЙН НӨХЦЛИЙН ИНЖЕНЕР Ц.ЦЭРЭНДУЛАМ

**Нийт усны хэрэглээ:**

-Цэвэр усны -200 м$^3$/хон

-Галын усны -5.0 л/с

-Бохир усны -200 м$^3$

**Бохир ус зайлуулах шийдэл:**

Бохир усны холболт хийх цэгийн байршил, шугамын диаметр: Төвийн бохир усны "Налайх" гол цуглуулах шугамын худагт шинээр шинээр салбар шугам татгадаж, дараагийн хэрэглэгч холбох.

Хэрэглэх усны хэмжээг "Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ын 14 дүгээр хавсралт "Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын ус хэрэглээний норм"-д зааснаар өрөөндөө онгоц, шүршүүртэй зочид буудлын 1 амрагчийн хоногийн дундаж усны хэрэглээ нь 200 л гэж тогтоосноор цогцолборын ажиллах хугацаа (365 хоног)-нд тооцсон.

Нийт хоногт 56.0м$^3$ (0.6 л/с), жилд 20440.0 м$^3$ ус ашиглахаар байна.Ногоон байгууламжийн усалгааг хур тунадасны ус хуримтлуулах, замаар буюу гадаргын усаар шийдвэрлэх боломжтой.



## 3.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай нь Улаанбаатар зүүн зүгт, хотын төвөөс 13 км-т Баянзүрх дүүрэг, 11-р хороо, Богд уулын ДЦГ, Хүрэлтогоотын аманд 15 га талбайд байрлана.




Төслийн талбай нь ДТД 1387-1411 метр өндарийн зөрүү 24 метр,газрын гадаргын хэвгий буюу налуу (4.9-6.9 градус) налуу гадаргууг тэгшилж барьсан байна.



### *3.1.Төсөл хэрэгжих талбайн орчны хөрсөн бүрхэвч, түүний онцлог:*

Төслийн талбай байрлах Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг орчим нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар Хангайн хөрс-био уур амьсгалын их мужийн Хэнтийн захын тойрогт хамаарна.Төслийн талбай бүхэлдээ уулын ердийн хар шороон хөрс /карбонатлаг биш/ хөрс тархсан байна.




**Температур:**Улаанбаатарын районд сарын дундаж агаарын температур (Буянт-Ухаагаар) хүйтний улиралд -1.3...-23.5°C, хот дотор (Улаанбаатар станцаар) -3.9°..-19.2°C, өндөрлөг газраар (Тэрэлж орчмоор) -2.2…-23.5°C хүйтэн, дулааны улирлын сарын дундажийг 7 дугаар сараар авч үзвэл 15.5-18.5°C байна.Эх газрын уур амьсгалын онцлогоос болоод жилийн хүйтэн улиралд агаарын температур газрын гадарга намсах тутам дулаарах, харин дулаан улиралд газар өндөрсөх тутам сэрүүсдэг байдал энд тодорхой харагдаж байна.Сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтээс авч үзвэл Улаанбаатар хотын жилийн дундаж температур хотын төвөөр 0.2-1°C хэм, хотын зах Тэрэлж, Нисэх орчмоор -1..-2.8°C хэм байна. Үүнийг өмнө олон жилийн дундажтай харьцуулвал Буянт-Ухаа орчмоор 2°C, хотын төвөөр 0.6°C хэмээр дулаарсан байна.

**Агаарын чийг, хур тунадас:** Үнэмлэхүй чийгшлийг агаар дахь усны уурын даралтаар илэрхийлнэ.Улаанбаатар хотод үнэмлэхүй чийгшил жилийн дундаж байдлаар 4.4-4.8 гПа байна. Усны уурын даралт агаарын температураас голчлон хамаарах тул өвөл Буянт Ухаад хамгийн бага, зун Тахилтад их, түүний жилийн явцын хамгийн их утга зун 11.2-12.3 гПа, хамгийн бага нь өвөл 0.5-1.0 гПа байна Улаанбаатарын хур тунадасны олон жилийн явцыг аваад үзвэл сүүлийн жилүүдэд огцом багасч байгаа харагддаг. Тухайлбал: 1961-2006 оны

байдлаар хур тунадасны хэмжээ 0.399 мм/жил-ийн хурдтай, 1981-2006 оны хооронд 1.357 мм/жил-ийн хурдтай, 1990-2006 оны хооронд 5.0 мм/жил-ийн хурдтай бууралт явагдаж байна. Уур амьсгалын дулааралтын дэвсгэр дээр энэ бүс нутагт хур тунадасны эрчим нэмэгдэж байна.

**Салхи:** Улаанбаатарын районд хотын төвөөр жилийн дундаж салхины хурд 1.4-1.9 м/с, Буянт-Ухаа орчмоор 2.9-3.1 м/с байна. Хамгийн их салхи ихтэй хаврын сарын салхины дундаж хурд 2.3-4.6 м/с байна. Янз бүрийн хурдтай салхины давтагдлыг аваад үзвэл өвлийн улиралд 0-1 м/с хурдтай салхи зонхилдог, хаврын улиралд 3-4 м/с-ийн хурдтай салхины давтагдал ихээхэн өсч зонхилох байдалтай болдог байх юм.

"Аялал жуулчлалын цогцолбор хотхон" төслийн талбай нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт байрлана.

### *3.2.Агаарын чанарын өнөөгийн байдал:*

Агаарын чанарын харуулын ажиглалт, хэмжилтийн дүнгээс харахад агаар дахь хүхэрлэг хийн ($SO_2$) дундаж агууламж нь 0.008мг/м$^3$, хамгийн их тодорхойлогдсон агууламж нь 0.012мг/м$^3$, хамгийн бага агууламж нь 0.005мг/м$^3$ байсан байна. Харин азотын давхар ислийн ($NO_3$) дундаж агууламж нь 0.010мг/м$^3$, хамгийн их агууламж 0.021мг/м$^3$, хамгийн бага агууламж нь 0.002мг/м$^3$ байсан нь MNS4585:2025 стандартын зөвшөөрөгдөх дээдхэмжээнээс давж бохирдсон тохиолдол гараагүй байна.Агаарын чанарын индексийн үнэлгээгээр стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байна.

### *3.3.Төслийн талбайн ургамлан нөмрөгийн төлөв байдал:*

Монгол орны ургамал газарзүйн тойргоор Монгол-Дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.). Ургамалжилтын хувьд ойт хээрийн бүслүүрт оршино. Тус бүслүүрийн онцлог нь уулархаг нутагт илэрч буй ой, нам газраар хээрийн элементүүд зонхилно. Өөрөөр хэлбэл ой, хээр хоёр зэрэгцэн оршдог.Хээрийн хэвшинжид хамаарах элдэв өвс-үетэнт, хялганат, хазаар өвст–хялганат, агь–хялганат, ботууль–агь элбэг тохиолдоно. Харин нугын хар хүрэн хөрстэй хөндий хажуу дагаж Саман ерхөг, ширэг улалж, Зүр–өвс, Яргуй, Тарваганшийр, Имт гичгэнэ, Тавилгана, Багваахай, Шарилж, Тавансалаа гэх мэт олон зүйлүүд нь хээржсэн нугад тааралдана.






### *3.4.Тусгай хамгаалалттай газар нутаг:*

Энэхүү төсөл нь Богд хан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд буюу Хүрэлтогоотын аманд хэрэгжинэ. Богд хан уулын дархан цаазат газрын нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 41651 га бөгөөд дотроо онгон, хамгаалалтын, хязгаарлалтын гэсэн 3 бүсэд хуваагдана. Онгон бүс нийт нутаг дэвсгэрийн 17.3 % буюу 7115.3 га, хамгаалалтын бүс 54.2 % буюу 22291.9 га, хязгаарлалтын бүс 28.5 % 11721.8 га талбайг тус тус эзэлдэг байна.



### 3.5.Нийгмийн суурь нөхцөл:

Улаанбаатар хотын зүүн талд байрлах Баянзүрх дүүрэг нь нийслэлийн хамгийн том дүүрэг бөгөөд Богд Хан Уулын Бага тэнгэр, Богино хүрхрээ, Чулуут, Бумбат, Залаат, Төр хурах ам болон Хар усан тохой зэрэг үзэсгэлэнт байгалийг цогцлоон нийт 124.4 мянган га газрыг хамарч оршдог.

Дүүрэг жил ирэх бүр хаяа тэлэн хөгжиж байгаагаас гадна хүн амын тоо ч өсөж байна. Тухайлбал сүүлийн таван жилийн хугацаанд тус дүүргийн хүн амын тоо 12 хувиар өссөн байна. 2022 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар 104,881 өрхийн 383,892 хүн байнга оршин сууж байна. Үүнээс 185,517 /48,3%/ нь эрэгтэй, 198,375 /51,7%/ нь эмэгтэй байна.

Баянзүрх дүүрэгт Монгол Улсын Шинжлэх ухааны академи, түүний харьяа 6 хүрээлэн, Оросын соёл шинжлэх ухааны төвөөс гадна хүүхэд залуучууд эх түүхийн жимээр аялах боломжтой Монгол цэргийн музей, Жуковын музей, Оюун ухааны музей тус тус байрладаг. Улсын хэмжээнд хамгийн томд тооцогдох Үндэсний цэцэрлэгт хүрээлэн мөн Баянзүрх дүүрэгт оршдог. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн нь нийт 973 га талбайг хамардаг. Үүнээс 183 га талбайд төлөвлөлт хийгээд байна. 300 га талбайд төлөвлөлт хийгдэх бөгөөд үүний 70 хувийг ногоон байгууламж эзэлж 30 зүйлийн 140,000 гаруй мод тарина. Энэ мэтчилэн Баянзүрх дүүрэг нь Байгалийн нөөц, түүх соёлын өв уламжлалыг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хангасан ногоон дүүрэг болох зорилт дэвшүүлсэн. Үүний хүрээнд 2030 он гэхэд 10 сая мод ургуулахаар төлөвлөөд байна.



## 4.ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд Хүрэлтогоотын аманд хэрэгжих "Аялал жуулчлалын цогцолбор хотхон" төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдал, бүс нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, түүний эрчимшил зэргийг магадлан жагсааж, болзошгүй нөлөөллийг БОННҮ-ний тайлангаас энд тодруулна.

Аялал жуулчлалын цогцолбор хотхон төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нийт нөлөөллийн эрчмийг ашиглалтын үе шатанд гэж ангилж үнэллээ.Үр дүнг нэгтгэж үзвэл 14 үзүүлэлтээр нөлөөллийн эрчмийг тодорхойлсноос барилгын ажлын үе шатанд 33.3 % нь нөлөөлөлгүй, 6.7% нь бага зэрэг сөрөг нөлөөлөл, 46.7% нь дунд зэрэг сөрөг нөлөө, 13.3% нь их сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг шаардлага хангасан түр цуглуулах цэг байгуулан түр цуглуулж, тогтмол хугацаанд зайлуулах тохиолдолд хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна.

Үйл ажиллагаагаар унд-ахуйн хэрэглээнд цэвэр ус ашиглах учир усны нөөцөд дунд зэрэг сөрөг нөлөө үзүүлэхээр байна. Усны чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй талаар БОННҮ-ний тайланд дурджээ.

### 4.1.2026 ОНД ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уг аялал жуулчлалын цогцолбор хотхон төслийн барилгын ажлыг 2026 онд дараах ажлуудыг хийихээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Барилга угсралтыг хийж ашиглалтад оруулах

2. Цахилгааны кабелийг барилгуудад холбох

3. Дулаан, цэвэр бохир усны шугамыг барилгуудад холбох

3. Ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэх

4. Үнэт мод тарих

5.Барилгын хог хаягдлыг тогтмол зайлуулах

6. Хөдөлмөр хамгааллыг сайтар хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### 4.2 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

- **Төслийн үед үүсэх тоосыг бууруулах;**

Барилгын бүтээн байгуулалтын үед техник хэрэгслийн үйл ажиллагаагаар салхи ихтэй үед тоосжилт үүсэж ойр орчмын агаарын чанарыг муутгах эрсдэлтэй. Бүтээн байгуулалт хийгдэж байгаа объектуудыг ойр орчмын суурьшлын бүсээс тусгаарлаж хашаалах нь тоосжилт бууруулахад багагүй нөлөөтэй.Хашаа хайс нь өндөр байх тусам салхиар хийсэх тоосонцрыг бууруулах нөлөөтэй.

- **Сайжруулсан замаас үүсэх тоосжилтыг бууруулах;**

**Усалгаа:**Замыг услах нь тоос дарах хамгийн энгийн арга юм. Энэхүү аргыг хэрэглэхэд замыг урьдчилан бэлтгэх шаардлагагүй бөгөөд ус шүршигч машинаар замын гадаргуур усалж норгоно.

Зам усалгааны машин нь усны нөөцлүүр, шахуурга, ус шүршигч цорготой байна, Цоргыг хувьд ихэвчлэн машины арын хэсэгт байрласан байдаг, Усны нөөцлүүрийн багтаамж

нь машины хүчин чадлаас хамааран янз бүр байдаг, Зарим усны машинд тоноглогдсон гидропульт нь операторын удирдлагаар эргэх боломжтой байх тул нурмаг боргио үүссэн байршлууд руу ус шүршин услах боломжтой байдаг, Ус шүршигч цорго нь хөдөлгөөнгүйгээр суурилагдсан байх хэдий ч цоргоны хийц бүтцээсээ хамааран ихэвчлэн цацраг хэлбэрээр усыг шүршдэг, тоос дарах усалгааны аргын дутагдалтай тал нь усалгааг тогтмол хугацаанд давтан хийх шаардлагатай байдаг, зарим судалгааны дүнгээр 1 метр квадрат талбайд 0.6 л ус зарцуулан усалгааг хийсний дараа нийт тоосжилт 30 минутын турш 95%-иар буурч байсан бол усны хэмжээг нэмэгдүүлэн 2л/$м^3$ болгоход 3-4 цагийн турш нийт тоосжилт 74% буурах боломжтойг тогтоосон байдаг.

- **Дуу чимээний бохирдол үүсэх:**

Физик бохирдол гэдэг нь тухайн орчинд байгаа дуу шуугианаас бий болох механик бохирдлыг хэлнэ.

Дуу шуугиан гэдэг нь аливаа хүсээгүй дуу чимээ бөгөөд агаарын орчныг бохирдуулагч физикийн бохирдуулагчдын нэг гэж үздэг.Дуу шуугианы бохирдлын өртөлтийг дам тамхидалттай холбож ойлгож болно. Дуу чимээний давтамжийг Гц-ээр хэмжээд үзүүлэх хүчний төвшинг Дб-ээр хэмжинэ. Энэ нь дуу чимээний чанга сулыг илэрхийлэх хэмжих нэгж юм. ДЭМБ-ын 1999 онд гаргасан удирдамж ёсоор хүрээлэн буй орчны дуу чимээ нь унтлагын өрөөнд 40 дБ (А)-ээс бага байхыг зөвлөдөг бөгөөд энэ орчинд унтаж амархад гүн нойрсолт явагдаж сайн унтаж амардаг байна. Харин ажиллах, амрах орчин, хотын дуу шуугианы стандарт хэмжээ нь:

- 07:00–23:00 цаг буюу 16:00 цагийн дундажаар 60 дБ,
- 23:00–07:00 цаг буюу найман цагийн дундажаар 40 децибеллээс хэтрэхгүй байх ёстой гэж тус тус үздэг.

**Дуу чимээний сөрөг нөлөөллийг бууруулах арга зам:**

Төслийн талбай, түүний орчимд Digital Sound Level Meter багаж ашиглан 1 цэгээс дуу шуугианы хэмжилт хийнэ.

Шуугианы хэмжилтийг MNS 6768:2019 "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага." стандарт аргачлалын дагуу тодорхойлно.

Монгол улсад MNS 4585:2025 стандартад заасанчлан өдрийн цагт 60 дБА (16 цагийн дунджаар), шөнийн цагаар 45дБА (8 цагийн дунджаар)-аас хэтрүүлэхгүй байх ёстой. Мөн ямар нэгэн үйл ажиллагаа явагдаагүй хөдөө нутагт дуу шуугианы түвшин дунджаар 30 дБА байдаг.

## *4.3.ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ*

Төсөл хэрэгжих явцад хөрс элэгдэж, эвдрэх, бохирдолд өртөх зэрэг сөрөг нөлөөлөлтэй тул доорх арга хэмжээг авж хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Ахуйн хатуу хог хаягдлыг хадгалах, цуглуулах, тээвэрлэх, устгах зайлуулах нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Био нойл ашиглах / Барилга тавих үед/
- Гүйцэтгэгч байгууллагууд шатахуун асгарахаас сэргийлэх онцгой байдлын төлөвлөгөөг боловсруулсан байх ёстой.

- Төслийн талбайд ашиглах нэгдсэн хогийн цэгийг стандартын дагуу тохижуулах, ангилан ялгах шаардлагатай.
- Олон нийтийн замд саад учруулахгүйгээр машин механизмуудад зориулан өөр зам эсвэл түр зуур ашиглах эгнээ гаргах нь зүйтэй.

**Хөрсний эвдрэл, доройтлоос хамгаалах арга хэмжээ**

Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хөрсний эвдрэл, доройтолт ихтэй байна. Цаашид үйл ажиллагаа үргэлжлэн явагдах тул дараахи сөрөг нөлөөллүүдээс сэргийлэх хэрэгтэй. Үүнд:

- Шугам хоолой татах явцад хүнд даацын техникүүд ихээр ашиглагдах тул ашиглалтын талбайн хаа сайгүй шороон замууд гарч хөрс ихээр зулгарч эвдэрч доройтно.
- Аюулгүй ажиллагааны үүднээс материал тээвэрлэх, зорчих хэсгүүдэд замын тэмдэг тэмдэглэгээ сайтар хийх,
- Бүтээн байгуулалтын ажил дууссаны дараа талбай түүний орчинд үүссэн нүх, далан шуудуу бүхий эвдэрсэн газруудад техникийн болон ногоон байгууламжийн нөхөн сэргээлтийг чанартай гүйцэтгэж газраа тэгшлэх,
- Эцэст нь ашиглалт явуулж байгаа талбай болон түүний орчмын нутагт байгаль орчны доройтолтой холбоотой ямар нэг зөрчил гаргахгүй ажиллах хэрэгтэй. Тухайлбал, эвдэрч доройтсон газруудаа нөхөн сэргээлт хийлгүй орхих зэрэг сөрөг үзэгдэл багтана.
- Хөрсний эвдрэл, доройтол, бохирдлыг хянаж байх мониторинг цэгүүдийг бий болгож хөрсний дээж авч шинжилгээ хийлгэж, шинжилгээний дүнг манай улсад мөрдөгдөж буй стандартууд болох "Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга" Монгол улсын стандарт (MNS 3310:1991)-аар хөрсний үржил шимийн түвшинг, мөн "Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" стандарт (MNS 5850:2019)-ын хүнд металлын хүлцэх агууламж, хортой болон аюултай агууламжтай харьцуулан дүгнэлт гаргаж байх шаардлагатай.

## *4.4.УРГАМЛЫН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ*

Төслийн үйл ажиллагаа болон машин техникийн хөдөлгөөний улмаас тухайн орчныг хамгаалах дараах арга хэмжээг дэс дараатай явуулах хэрэгтэй. Үүнд:

- Орчныг хамгаалах ногоон зурвас байгуулж хамгаалах арга хэмжээг авах шаардлагатай.
- Хог хаягдлыг дүүргийн тохижилт үйлчилгээний газартай гэрээ хийн хог хаягдлыг зайлуулж байх шаардлагатай.
- Шороо тоос босож орчны ургамалжилтад нөлөөлж, ургалт удааширна.

*Ургамлан нөмрөгийн доройтлыг бууруулах арга зам нь доорх байдлаар хэрэгжинэ. Үүнд:*

- Ургамлын доройтол үүсэх болон үүсэхгүй газруудад хил хязгаар бий болгох,
- Байгалийн ургамал болон нөхөн сэргээсэн ургамалтай талбайг тороор хаших нь түүнийг хамгаалах ач холбогдолтой.
- Төслийн талбайд мод бутыг хөндөхгүй байх, хөндсөн тохиолдол өөр газар шилжүүлэн тарих зайлшгүй шаардлагатай.

## *4.5.ГАЗАР ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ*

Төслийн үе шатанд дараах болзошгүй нөлөөлөл үүсэхээр байна.

- Шатахуун тос тослох материал асгарсан тохиолдолд хур бороны усаар угаагдан хөрсөнд нэвчин бага гүний уст үеүдийг бохирдуулах

## 4.6.ТХГН, ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛСТ УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Дулааны шугамын газар шорооны ажлын үед өмнө нь судалж тогтоож чадаагүй археологийн болон түүх соѐлын үлдэц, үнэт зүйлс өртөж болзошгүй.

## 4.7.НИЙГЭМ, ХҮН АМД НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн үйл ажиллагаанаас ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд дараах сөрөг нөлөөлөл үүснэ. Үүнд:

- Төслийн талбайн ажилчдын тав тухтай байдал дутагдах, хөдөлмөрийн сахилга бат хариуцлага зөрчигдөх, харуул хамгаалалтын журам алдагдсанаас зохисгүй харьцаа үүсэх, гэмт хэрэг гарах, халдварт өвчин тархах аюул үүсэж болзошгүй

## 4.8.ХОГ ХАЯГДАЛ

Төслийн үйл ажиллагаанаас ахуйн хог хаягдал, төслийн ажлын явцад ахуйн болон барилга барих үед гарах хог хаягдал үүсэх бөгөөд хог хаягдал үүсэх, тэдгээрийг хадгалах, устгахтай холбоотойгоор сөрөг нөлөөлөл бий болно.

- Төслийн үйл ажиллагаанаас жишээ нь ухалтын ажлаас гарсан хөрс шороо болон ердийн хатуу хог хаягдал үүсэх,
- Ахуйн бохир ус зэрэг шингэн хаягдал үүсэх,
- Аюултай хог хаягдал болох ажилласан тос, тос тослох материалын сав, сольсон сэлбэг хэрэгсэл зэргийг зохих журмаар устгаагүй тохиолдолд байгаль орчныг бохирдуулах сөрөг нөлөөтэй

## *5.ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ ГОЛ ЗОРИЛТ*

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо, Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлах "Ланд энд Хаус" ХХК-ийн "Аялал жуулчлалын цогцолбор хотхон" төслийн 2026 оны БОМТ-г БОАЖЯ-ны сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ыг баримтлан боловсруулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь **байгаль хамгаалах төлөвлөгөө**, **орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс** бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тусгахаар хуульчлагдсаныг баримтлан боловсруулав.

**"Нью гидро проект" ХХК-ийн батлуулсан БОННҮ-ний тайлангийн 115 дугаар нүүрэнд тусгасан БОМТ-ний 5 жилийн нэгдсэн төсөвт БОТМ-ын 2026 онд 5750.0 мянган төгрөг гэж тэмдэглэсэн байна.**

**Хүснэгт 7- 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв, мян.төг**

| № | Зардлын ангилал | 2024 он | 2025 он | 2026 он | 2027 он | 2028 он |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 9700.0 | 10000.0 | 3300.0 | 11300.0 | 8800.0 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 10000.0 | 23000.0 | - | - | - |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө | Газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт үл хамаарах тул биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа хийхгүй. | | | | |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө | Төслийн хэрэгжилтийн үед нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох үйл ажиллагаа явагдахгүй. | | | | |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө | - | - | - | - | - |
| 6 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | - | 1300.0 | 1100.0 | 1100.0 | 1100.0 |
| 7 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 1110.0 | 1710.0 | 1350.0 | 2600.0 | 1600.0 |
| 8 | Бомт, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь | - | - | - | - | - |
| Дүн | | 20810.0 | 36010.0 | 5750.0 | 15000.0 | 11500.0 |
| Аялал жуулчлаын цогцолбор хотхон төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт төсөв /2024-2028 он/ | | 89'070.0 | | | | |

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛД 5750.0 (ТАВАН САЯ ДОЛООН ЗУУН ТАВИН МЯНГА) ТӨГРӨГ ТӨЛӨВЛӨЛӨӨ.**

2026 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг дараа оны 12-р сарын 01-ний дотор **НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАРТ** ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна.

**Хүснэгт 2." БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 1 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ"-НИЙ НЭГДСЭН ДҮН**

| **№** | **Хэрэгжүүлэх арга хэмжээ** | **Тухайн жил БОМТ (Зардал мян.төг)** |
|---|---|---|
| | | **2026 он** |
| 1. | Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 2750.0 мян.төг |
| 2. | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө | 700.0 мян.төг |
| 3. | Түүх, соёлын өвийг хамгаалах | "Түүх, соёлын-р өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө"-г тусгайлан боловсруулах шаардлагагүй. |
| 4. | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 600.0 мян.төг |
| 5. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 300.0 мян.төг |
| 6. | БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардал | 350.0 мян.төг |
| 7 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 750.0 мян.төг |
| 8. | Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө | 300.0 |
| **БОМТ-ний 2026 оны жилийн зардал** | | **5750.0 мян.төг** |

## *6.АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хороо, Богдхан уулын ДЦГ-ын Хүрэлтогоотын аманд байрлах “Ланд энд Хаус” ХХК-ийн “Аялал жуулчлалын цогцолбор хотхон” төслийн 2026 онд хэрэгжүүлэх “Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”

***Хүснэгт 3.“Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”***

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хуга-цаа | Тоо хэмжээ | Нэгж үнэ, мян.төг | Нийт зардал мян.төг | Хэрэг-жүүлэгч | Биелэл-тийн шалгуур | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Газар шорооны ажлын үед тоосжилт үүсч агаар орчныг бохирдуулах, Төслийн тоног төхөөрөмж, машин механизмаас бохирдуулагч бодисууд ялгарч агаар орчныг бохирдуулах. | Газар шорооны ажлын улмаас шороо тоос босгохгүйн тулд төслийн үйл ажиллагаа явагдаж буй талбайд тоос дарах усалгаар хуурай өдрүүдэд 1 $м^2$ талбайд 2-4 л нормын дагуу өдөрт 3-4 удаа тогтмол усалгаар хийх | Барилгын ажил гүйцэтгэх талбай | 2026 онд | Усны хэмжээ тонн | ** | 200.0 | “Ланд энд хаус” ХХК | Тоосжилт агаарын бохирдол буурна | Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль<br><br>**MNS4585:2025** Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,<br><br>**MNS5885:2008** Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм |
| 2 | | Ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, утаа их хаядаг, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг барилгын ажлын талбайд гаргахгүй байх Тээврийн хэрэгсэл болон хүнд даацын машин механизмын хөдөлгүүрийн тохиргоо, оношлогоо үйлчилгээг тогтмол хийх Тээврийн хэрэгслийн утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих аргын стандартын /MNS 5013:2009, MNS5014:2009/ дагуу хянаж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байлгах | Ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд | 2026 онд | ** | ** | 100.0 | “Ланд энд хаус” ХХК | Тоосжилт агаарын бохирдол буурна | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | | Барилгын талбайн цэвэрлэгээг өдөр тутам хийж, барилгын хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт тогтмол зайлуулж байх | Төслийн талбай | 2026 онд | ** | ** | ** | | Тоосжилт агаарын бохирдол буурна | хэмжээ.<br><br>**MNS4990:2023** Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, ЗДХ |
| 4 | | -Технологийн доголдлын үед гарах ослоос урьдчилан сэргийлж, ослын үед авах арга хэмжээнүүдийг нөлөөллийн хэлбэр бүрээр үйл ажиллагааны туршид хэрэгжүүлэх | Дулааны шугам барих ажлын талбай | 2026 онд | ** | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Осол эрсдлээс сэргийлнэ | |
| 5 | Барилгын газар шоровны ажлаас дуу чимээ үүсэх | Барилгын ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэг, оношлогоо, засварыг сар бүр хийж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гарахыг хориглох Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх. Зуны ажлын үеэр ажлын цагийг аль болох хязгаарлах. Тухайлбал, 10-14 цаг.Ялангуяа төслийн үйл ажиллагаанд ашиглаагүй үед тээврийн хэрэгсэл, машин механизмыг унтраах.Дуу чимээний мониторинг хэмжилт хийж хяналт тавих | Дулааны шугам барих ажлын талбайд | 2026 онд | ** | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Үйл ажиллагааны туршид | |
| 6 | | Иргэд, АНН байгууллагууд зэрэг ойр орчмын нөлөөлөлд өртөх бүлгүүдэд дуу шуугиан үүсгэх дулааны шугамын ажлын талаар урьдчилан мэдэгдэл хүргүүлэх | Ойр орчмын айл өрх, ААН байгууллага | 2026 онд | ** | ** | 100.0 | "Ланд энд хаус" ХХК | Ажил эхлэхээс өмнө | |
| 7 | Төслийн үйл ажиллагаанаас агаар орчин бохирдох | Агаар бохирдуулагч үзүүлэлтүүдээр ОХШХ-ийн дагуу хянах | Барилгын ажлын талбай | 2026 онд | тогтмол | ОХШХ-т тусгах | ОХШХ-т тусгах | "БОХТЛ" | Хяналт мониторинг сайжирна | |
| | **Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал** | | | **400.0 мян.төг** | | | | | | |

## *6.1.ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Нэгж үнэ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хөрсний үржил шим алдагдах, эвдрэл үүсэх | Нөлөөлөлд өртөөгүй эрүүл талбайг хөндөж хөрс хуулах бол өнгөн хөрсийг тусгай талбайд хадгалж, Дулааны шугамын ажил дууссаны дараа эвдэрсэн талбайг нөхөн сэргээхдээ ашиглах, аль болох богино хугацаанд хөрсийг нөхөн сэргээж элэгдлээс хамгаалах | Барилгын ажлын талбай | ** | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Газар шорооны ажлын үед | "Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль"<br><br>**MNS 6260 : 2020** Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах<br><br>**MNS5850:2019.** "Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ" |
| | Хөрсний үржил шим алдагдах, эвдрэл үүсэх, барилгын хог хаягдлаар бохирдох | Барилгын ажлын үед нэг цэгээс дараагийн цэг рүү шилжих шилжилт тутамд засвар дууссан газрын нөлөөлөлд өртсөн гадаргыг нөхөн сэргээж ухаш, овоолго үлдээхгүй байх, хатуу хог хаягдлыг тогтмол түүж цэвэрлэх | Бариллгын ажил явагдах бүх талбайд | ** | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав | |
| | Газрын гадаргын төрх байдалд түр хугацааны өөрчлөлт орох | Газар шорооны ажлаас бий болох шороон материалын овоолгыг үүсгэхдээ орц, гарц, зам талбайг хааж, хөдөлгөөнд | Барилгын ажил явагдах бүх талбайд | ** | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд багтсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | саад учруулахгүйгээр тооцож байрлалыг сонгох Газар шорооны ажил дуусмагц шороон материалын овоолго байрласан цэгт талбайн цэвэрлэгээ хийх, газрын төлөв байдлыг сайжруулах | | | | | | | |
| | Барилгын материалын болон ахуйн хаягдлаар орчныг бохирдуулах | Барилгын материалын хаягдлыг богино хугацаанд төслийн талбайгаас зайлуулах, хог хаягдлыг нэг цэгт төвлөрүүлэх, үүссэн хаягдлыг хийсч тархахааргүй битүүмжлэл сайтай цэгт түр хадгалах арга хэмжээ авах | Барилгын ажил явагдах бүх талбайд | ** | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Үйл ажиллагааны зардалд багтсан | |
| | Хөрсийг нефтийн бүтээгдэхүүн, хүнд металлаар бохирдуулж болзошгүй. | Бензин, шатах тослох материалыг асгарч, ууршихааргүй байдлаар сайтар таглаж битүүмжлэн нарны шууд тусгал, галын эх үүсвэрээс тусгаарлан хадгалах, шатах тослох материалаар хөрс бохирдохоос сэргийлэх | Барилгын ажил явагдах бүх талбайд | ** | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Үйл ажиллагааны зардалд багтсан. | |
| | Тээврийн хэрэгсэл, хүний байнгын хөл хөдөлгөөнөөс үүдэн хөрсний | Хөрсний эвдрэл талхагдал үүсэхээс сэргийлж материал, хаягдал шороон материал тээвэрлэх хүнд даацын | Дулааны шугамын ажил дууссаны дараа | ** | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Нөхөн сэргээлт, тохижилтын ажлын төлөвлөгөөнд багтсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | элэгдэл, доройтол үүсэх | машинуудыг тогтсон маршрутаар зорчуулах Барилгы ажил дуусах үед хөрс суларч доройтон, хөрсний элэгдэл үүссэн газруудад нөхөн сэргээлт хийх | | | | | | | |
| | Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч гоожин хөрсөнд нэвчсэнээр хөрсөн бүрхэвчийн бохирдол үүсгэж болзошгүй | Төслийн ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх | Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд | ** | ** | 400.0 | "Ланд энд хаус" ХХК | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав | |
| **Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал** | | | | | **400.0 мян.төг** | | | | |

## *6.2.УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хугацаа | Тоо хэмжээ | Нэгж үнэ, мян. төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тос тосолгооны материал санамсаргүй байдлаар асгарч, хур борооны усаар зөөгдөх буюу хөрсөнд нэвчих байдлаар газрын доорхи усны чанарт дам байдлаар нөлөөлж болзошгүй. | -Барилгын ажилд ашиглагдаж буй машин техникт түлш цэнэглэх ажлыг зөвхөн ШТС буюу цементэлсэн талбайд хийж гүйцэтгэх барилгын ажилд ашиглагдаж буй машин техникийг ажлын талбарт гарахаас өмнө өдөр бүр үзлэг хийж, тос тосолгооны материал хөрсөнд асгарч алдагдахаас сэргийлэх<br>-Шатах тослох материал асгарсан үед, хөрсний бохирдол үүсэхээс сэргийлж синтетик шингээгч материал (TSSW50W) ашиглан шингээж авах | Барилгын ажилд ашиглагдах бүх тээврийн хэрэгсэл, машин механизм | 2026 онд | Синтетик шингээгч материал (TSSW50W), 6 ширхэг | 100.0 | 200.0 | "Ланд энд хаус" ХХК | Дулааны шугамын ажлын туршид | **-MNS 6148:2010** "Усны чанар.Газар доорх усыг бохирдуулагч бодисын ЗДХ"<br><br>**"MNS 4943:2015** Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага" |
| Усны нөөцийг хэмнэх | -Дахин цэвэрлэсэн ус ашиглах<br>-Борооны усыг ашиглах<br>-Гадаргын ус ашиглах | Усны нөөцийг хэмнэх | 2026 онд | ** | 300.0 | 300.0 | "Ланд энд хаус" ХХК | Ногоон хөгжлийн бодлогыг төлөвшүүлэх | |
| **Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал** | | | | **500.0 мян.төг** | | | | | |

## *6.3. УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

**Хүснэгт 4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Нэгж үнэ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Барилгын ажлын нөлөөгөөр байгалийн ургамлан нөмрөг, устах, доройтох | | Төс-лийн талбай | ** | ** | 200.0 | "Ланд энд хаус" ХХК | (Хавар, намрын улиралд) | Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль |
| Шинээр тарьсан үнэт модыг арчлах, хамгаалах | Төслийн талбайд тарьсан модыг арчлах, услах, хамгаалах | Төс-лийн талбай | ** | ** | 150.0 | "Ланд энд хаус" ХХК | Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед | **MNS 6774:2019** Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах. Техникийн шаардлага |
| Шинээр зүлэгжүүлсэн талбайг арчлах, тордох, хамгаалах | Төслийн талбайд тарьсан зүлгийг арчлах, услах, хамгаалах | Төс-лийн талбай | ** | ** | 100.0 | "Ланд энд хаус" ХХК | Барилгын ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх цаг үед | **Зүлэг тарих арга** |
| **Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал** | | | | **450.0 мян.төг** | | | | |

## *6.4.НИЙГЭМ, ОЛОН НИЙТЭД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

**Хүснэгт 5.Нийгэм, олон нийтэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Нийт зардал, төгрөг | Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Газар шорооны ажлуудаас тоосжилт үүсэх | Газар шорооны ажил явагдаж буй цэгүүдэд 1 $м^2$ талбайд 2-4л нормын дагуу тогтмол усалгаа хийх Хүчтэй салхи шуургатай үед тоосжилтыг багасгах үүднээс газар шорооны ажлыг түр зогсоох | Төслийн талбай | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Хуурай өдрүүдэд, өдөрт 4-5 удаа | **-MNS 5885:2008** Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага<br><br>**-MNS 4990:2023** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ.<br><br>**-MNS 4585:2025** Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага<br><br>**-MNS 6808:2019** Явган хүний зам, талбайн төлөвлөлт. техникийн шаардлага |
| 2 | Газар шорооны ажлуудаас дуу чимээ үүсч ойр орчмын оршин суугчдын тав тухыг алдагдуулах | Барилгын ажилд ашиглагдаж буй автомашинуудыг техникийн үзлэгт сар бүр оруулж, хэт их дуу чимээтэй, стандартад нийцэхгүй тээврийн хэрэгслийг ажлын талбайд гаргахгүй байх Дуу чимээ ихтэй ажлуудыг зөвхөн өглөөний 08:00 цагаас оройн 19:00 цагийн хооронд гүйцэтгэх<br>Зуны барилгын ажлын үеэр ажлын цагийг аль болох хязгаарлах. Тухайлбал, 10-14 цаг.Ялангуяа овоолго хийх гэх мэт үйл ажиллагаанд ашиглаагүй үед тээврийн хэрэгсэл, машин механизмыг унтраах | Барилгын ажлын талбай | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | ОХШХ-т тусган оруулсан | |
| 4 | Үйл ажиллагааны үед зам тээврийн осол аваарь гарах буюу ажилчдын аюулгүй байдалд эрсдэл учруулах | Хүнд даацын машины жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын давтан сургалтад хамруулах, үүсч болзошгүй эрсдэл, осол аваарийн талаар тайлбарлан таниулах тээврийн машины хурдыг хязгаарлах дүрэм мөрдүүлэх, осол аваарь гарах эрсдэл бүхий цэгүүд дээр 5 секунд зогсоод хөдлөх дүрэм мөрдүүлэх | Тээврийн хэрэгслийн жолооч нар | Сургалтын тоо | 400.0 | 400.0 | Ажил эхлэхээс өмнө | |
| 5 | Төслийн орчинд хог хаягдал, бохир усыг замбараагүй зайлуулснаас үүдэн | Төслийн ажил явагдах талбай бүрт дараах эрүүл ахуйн үндсэн шаардлагууд тавигдана. Үүнд: 1. Хатуу хог хаягдлыг түр хадгалах зориулалтын цэг бий болгож, хашлага | Төсөл хэрэгжих талбай | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | орчны бохирдол, үнэр танар үүсгэх | хамгаалалт хийж, тэмдэг тэмдэглэгээ байршуулах, Баянзүрх дүүргийн ТҮК-тэй хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг 7 хоногт 2 удаа ачуулж байх | | | | | | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль<br><br>**-MNS 4968:2026** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага |
| 6 | Төслийн орчинд сахилга бат, хэв журмын зөрчил гаргаж оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах | Төслийн ажилчдыг БОМТ, эрүүл ахуйн сургалтад хамруулж, зөрчлийн хуулийн холбогдох заалтуудыг сурталчлан таниулсан байх Ажилчид мөрдөх дотоод журамд сахилга батын асуудлыг нарийвчлан тусгаж өгөх ба үүнд согтууруулах ундаа хэрэглэх, ойр орчмын оршин суугчидтай асуудал зөрчил үүсгэх зэргийг хатуу хориглох | Төслийн бүх ажилчид | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Барилгын ажил эхлэхээс өмнө | |
| **Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал** | | | | | **400.0 мян.төг** | | | |

## Хүснэгт 6. Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Нэгж үнэ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Гүйцэтгэгчийн БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх | Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь Нийслэлийн Байгаль Орчны Газраас батлагдсан энэхүү БОМТ-ийг хэрэгжүүлэх | Гүйцэтгэгч байгууллагын удирдлага | ** | ** | ** | Мэргэжлийн байгууллагатай хамтрах | БОМТ-ний хэрэгжилт хангагдана. | Байгаль орчныг хамгаалах тухай хууль, |
| 2. | БОМТ-г хэрэгжүүлэх бүтэц зохион байгуулалт, боловсон хүчинтэй байх | Барилгын ажлын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь талбайн байгаль орчны ажилтантай байх ба уг ажилтан нь БОМТ-г боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, Барилгын ажлын талбарт өдөр тутмын БО-ны хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. | Гүйцэтгэгч байгууллагын удирдлага | ** | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | БОМТ-ний хэрэгжилт хангагдана. | Байгаль орчны үнэлгээний тухай хууль<br>**MNS 6231:2011** Тусгай зориулалтын ажлын хувцас. |
| 3. | Байгаль орчныг хамгаалах чиглэлээр инженер, ажилчдыг чадавхижуулах | Бүх ажилчдыг хамруулсан БО-ны сургалт зохион байгуулж, БО-ны чиглэлийн хууль, журмын шаардлага, стандарт, БОМТ-д тусгагдсан бууруулах арга хэмжээг тайлбарлан таниулна. | Гүйцэтгэгч байгууллагын удирдлага | сургал-тын тоо | 1 | 100.0 | 100.0 | Дулааны шугам барих ажил эхлэхээс | Ерөнхий шаардлага<br>**MNS 4931:2026** |
| 4. | ХАБЭА-н дүрэм зөрчигдөх, осол аваар гарах | Ажилчдад ажил эхлэхээс өмнө ХАБЭА-н зааварчилгаа өгч, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх | Бүх ажилчид | | | | | Дулааны шугам барих ажлын үед өдөр бүр | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн аюулгүй байдал. |
| 5. | | Машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн | Бүх тээврийн хэрэгсэл, машин механизмууд | | | | | | Хамгаалах хэрэгсэл. Ерөнхий |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангасан байх, эвдэрч доголдсон тоног төхөөрөмжийн ашиглалтыг нэн даруй зогсоох | | | | | | | шаардлага, ангилал |
| 6. | Анхны тусламж үзүүлэх эм тариа, багаж хэрэгсэл байхгүйн улмаас ослын нөхцөлийг хүндрүүлэх | Ажилчдад аливаа болзошгүй аваар ослын үед анхны тусламж үзүүлэх сургалт зааварчилгаар өгч, анхны тусламжийн эм тариа, багаж хэрэгслийг бэлэн байлгах | Бүх ажилчид | ** | 500.0 | 500.0 | “Ланд энд хаус” ХХК | Барилга барих ажлын үед өдөр бүр | |
| **Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний зардал** | | | | | **600.0 мян.төг** | | | | |

## *7.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

Энэ хэсэгт орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээ; хамрах хүрээ; тоо хэмжээ; нэгжийн болон нийт зардал; хэрэгжүүлэх хугацаа ба давтамж; баримтлах стандарт, аргачлал; шаардагдах зардлыг тусгав.

**Хүснэгт 7.Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө**

| Сөрөг нөлөөлөл бууруулах, арилгах арга хэмжээ | Хугацаа давтамж | Нийт зардал мян.төг | Хэрэгжүүлэгч | Биелэл-тийн шалгуур | Баримтлах хууль, журам стандарт |
|---|---|---|---|---|---|
| Дулааны шугамын ажлын төлөвлөсөн хил хязгаарт үйл ажиллагаа явуулах | Дулааны шугам барих ажлын турш | Үйл ажиллагааны зардалд багтсан | “Ланд энд хаус” ХХК | Орчны тохижилт хэвийн болно; | Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль<br><br>Газрын тухай хууль,<br>**MNS 5918:2023**<br>Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий шаардлага стандарт |
| Техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж, хүн амьтанд аюулгүй орчныг бүрдүүлж өгөх | Тухайн бүрд | Үйл ажиллагааны зардалд багтсан | “Ланд энд хаус” ХХК | Орчны тохижилт хэвийн болно; | |
| Ухсан нүх, цооногийг булж тэгшилсний дараа үржил шимт хөрс, хайргаар хучиж ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх | Тухайн бүрд | Үйл ажиллагааны зардалд багтсан | “Ланд энд хаус” ХХК | Орчны тохижилт хэвийн болно; | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Ногоон байгууламж хийх газруудад мод, зүлэг тарих | Газар шорооны ажил дууссаны дараа | 700.0 | "Ланд энд хаус" ХХК | Орчны тохижилт хэвийн болно: | |
| **Ногоон зурвас байгуулах төлөвлөгөөний зардал** | | | **700.0 мян.төг** | | |

## *8.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

Төслийн хүрээнд дулааны шугам тавих талбай, тэдгээрийн ойр орчимд түүх, соёлын өв, дурсгалт газрууд байхгүй болох нь төсөл хэрэгжих талбайд хийгдсэн суурь судалгааны явцад тогтоогдсон.

**Хүснэгт 8.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Нийт зардал, төгрөг | Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Өмнө нь судалж тогтоож чадаагүй археологийн болон түүх соёлын үлдэц, үнэт зүйлс дулааны шугамын ажлын үед өртөж болзошгүй | Газар дээр ил гараагүй байсан археологийн буюу палеонтологийн зүйлс санамсаргүй байдлаар илэрсэн тохиолдолд тухайн цэг дээрх барилгын шугамын ажлыг түр зогсоож, Баянзүрх дүүргийн захиргаа болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэж холбогдох арга хэмжээ авах | Барилгын ажлын талбай | Ажил эхлэхээс өмнө | ** | Түүх соёлын өв хариуцсан газруудтай хамтарч ажиллах | Соёлын өв хамгаалагдана. | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |
| **Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний зардал** | | | | | ** | | | |

## *9.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ*

Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагагүй.

## *10.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ*

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба тус төсөл нь барилгын ажил төсөл учир дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй болно.

## *11.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

Байгалийн гамшиг, аюулт нөхцөл байдал болон төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдал, байгаль орчинд үзүүлж болзошгүй осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж энэ хэсэгт оруулав.

**Хүснэгт 9.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэгч, хамтран хэрэгжүүлэгч | Биелэл-тийн шалгуур | Хууль эрх зүйн шаардлага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1. Байгалын гамшиг, аюулт нөхцөл байдал** | | | | | | | | |
| 1. | Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс төслийн үйл ажиллагаа доголдох, зогсох | Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах | Барилгын ажлын талбай | Ажил эхлэхээс өмнө | 100.0 | "Ланд энд хаус" ХХК | Үйл ажиллагаа | -Техникийн аюулгүйн дүрэм<br>-Гамшиг ослын бэлэн байдлын төлөвлөгөө |
| 2. | Аянга цахилгаан, үер усны аюул | -Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх<br>-Дулааны шугамын суурь ухах газар шорооны ажлыг хур борооны улирлаас урьтаж хийж дуусгах | Шороон материалын овоолго | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Дулааны шугам, цахилгаа-ны шугам тавих ажлын туршид | -Гамшгаас хамгаалах тухай хууль<br>-Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбД 30.01.03 |
| 3. | Газар хөдлөлт | -Онцгой байдлын үед гамшгаас хамгаалах арга хэмжээ авах талаарх сургалтад ажилчид, инженерүүдийг хамруулах | Бүх ажилчид, инженерүүд | 1 | 400.0 | "Ланд энд хаус" ХХК | | |
| | | -Газар хөдлөлтийн үед цугларах цэг тогтоож, самбар байршуулах | Төслийн талбайд | 3 | 150.0 | "Ланд энд хаус" ХХК | | |
| 4 | Гал түймэр | Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах | Төслийн талбай | 1 | 100.0 | "Ланд энд хаус" ХХК | Ажил эхлэхээс өмнө | Галын аюулгүй байдлын тухай хууль |
| | | Ажилчдад тогтмол зааварчилгаа өгч ажиллах. Галын болзошгүй аюул, ослын үед авах арга хэмжээний бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг "Галын аюулгүй байдлын тухай хууль"-ийн шаардлагад нийцүүлж хийх. Гал гарсан тохиолдолд газар авхуулахгүй унтраах анхан шатны арга хэмжээ авах, Онцгой байдлын албанд цаг алдалгүй мэдээлэх | Төслийн талбай | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Үйл ажиллагаа ны туршид | Галын аюулгүй байдлын тухай хууль<br>**MNS 4244:1994** Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2. Осол эрсдэл, өвчлөл** | | | | | | | | |
| **3. Газар шорооны ажил** | | | | | | | | |
| 5. | Ухсан нүхэнд хүн унаж осолдох | Газар шорооны ажлын цэгийг тойруулан хамгаалалтын хашлага татаж гэрэл ойлгогч бүхий анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ харагдахуйцаар байрлуулах | Газар шорооны ажил явагдах цэгүүд | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | Газар шорооны ажил явагдах хугацаанд | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, **MNS 4990:2023** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ. |
| 6. | Газар ухах ажлын үед хөрсөнд нуралт үүсч осол гарах | Ажил эхлэхийн өмнө, ажлын явцад хэвгий хэсэг, хөрсний бүтцийг шалгах, ачааны машины даацыг тохируулах, нурах эрсдэлтэй газарт ажилчид нэвтрэхийг хориглох, хөрсийг тохирсон хэмжээнд ухах, ухсан нүхний хана хөрсний усны үйлчлэлээр нурж болохуйц нөхцөлд бэхэлгээ хийнэ. | Газар шорооны ажил явагдах цэгүүд | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | |
| 7. | Газар шорооны ажлын механизмаас үүдэлтэй осол | Тээврийн хэрэгсэлд шороо ачиж байхад экскаваторын шанагын үйлчлэх хүрээнд хүмүүс байлгахыг хориглоно | Газар шорооны ажил явагдах цэгүүд | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм БНбД 12-04-06 |
| 8. | Мэдээлэл холбоо, цахилгаан хангамжийн утас шугамыг хөндөж гэмтээх | Газар шорооны ажил явагдах орчинд буй шугам сүлжээний зургийг сайтар судалж ажлаа төлөвлөх, | Газар шорооны ажил явагдах цэгүүд | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | Төсөл эхлэхээс өмнө | |
| **4.Барилга барих бүтээн байгуулалтын ажил** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | Техник, технологийн эвдрэл гэмтэлээс үүдэлтэй осол | Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах Машин, тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж ба бусад механикжуулалтын хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг өөрийн хүчээр буюу төрөлжсөн мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийлгэж байх | Нийт тээврийн хэрэгслүүдэд, багаж тоног төхөөрөмж | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | Дулааны шугам тавих ажлын туршид | **-MNS 4470:2005** Авто тээврийн хэрэгслийн хэрэглээний үзүүлэлтүүд. Ангилал, Ерөнхий шаардлага<br><br>-Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм- БНбД 12-03-04<br><br>**-MNS4930:2000** Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага<br><br>**-MNS 4598:2011** Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага<br><br>**MNS 6768:2019** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага |
| 10. | | Машин, тээврийн хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй<br>ажиллагаа, эрүүл ахуйн холбогдох стандартын шаардлагыг хангаж байх, харин тэдгээр нь дахин хэрэглэгдэж байгаа бол хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцэх эсэхийг баталсан гэрчилгээтэй байх | Нийт тээврийн хэрэгслүүдэд, багаж тоног төхөөрөмж | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | |
| 11. | Техник, тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй осол | Машин мехнизмын бүрэн бүтэн байдлыг шалгах, машин мехнизмын ард улаан гэрэл, дохиолол тавих, | Бүх тээврийн хэрэгсэлд | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | |
| 12. | | Ажил явагдах байр, орчинд ажил гүйцэтгэхтэй холбоогүй хүмүүс байхыг хориглоно. | Бүх тээврийн хэрэгсэлд | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | |
| 13 | | Машин механизмууд ухрах хөдөлгөөний үед 3 км/цаг -аас илүүгүй байх | Бүх тээврийн хэрэгсэлд | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | |
| 14 | | Машин механизмын сохор бүсэд нэвтрэхээс зайлсхийх | Бүх тээврийн хэрэгсэлд | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | |
| 15 | | Хараа хяналтгүйгээр машин, тээврийн хэрэгсэл, механикжуулалтын багаж хэрэгслийг хүчдэлд залгаатай, ажиллаж байгаа байдлаар орхихыг хориглоно | Бүх тээврийн хэрэгсэлд | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | |
| 16 | Гагнуурын оч үсэрч хүн гэмтэх | Гагнуур хийж буй ажилтанд зориулалтын хөдөлмөр хамгааллын хэрэгсэл өмсөх, гагнуур хийгдэж буй цэгийг хашиж хамгаалах | Холболт, гагналтын ажил явагдах бүх цэгт | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | |
| 17 | Дуу шуугианы нөлөөний улмаас ажилчдын эрүүл мэнд хэсэгчлэн муудах | Ажилчдыг сонсгол хамгаалах хэрэгсэл /чихэвч/-ээр тогтмол хангах | Бүх ажилчид | ** | ** | “Ланд энд хаус” ХХК | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **5. Тээвэрлэлтийн болон ачиж буулгах ажил** | | | | | | | | |
| 18 | Барилгын ажилд ашиглагдаж буй машин техник зам тээврийн осол гаргах | Ажилд оролцох жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны сургалтад давтан хамруулах | Бүх тээврийн хэрэгсэл | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | ажил эхлэхээс өмнө | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль<br>- Замын хөдөлгөөний дүрэм |
| 19 | | Аюулгүй ажиллагааны журмыг чанд мөрдүүлэх, | | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Өдөр тутам | |
| 20 | | Техникийн бүрэн байдлыг тогтмол шалгах, Төслийн тээвэрлэлт хийх гэр хорооллын доторхи зам, төслийн талбай доторх замд хурдны хязгаар тогтоох | | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Өдөр тутам | |
| 21 | Барилгын материал ачиж буулгах явцад осол гарах | Ачиж, буулгах ажил гүйцэтгэх байр, ачаа өргөх машины ажлын бүсэд, энэ ажилд хамааралгүй гадны хүмүүс байхыг хориглоно. | Ачиж буулгах тээврийн хэрэгсэл | ** | ** | "Ланд энд хаус" ХХК | Өдөр тутам | **-MNS 5079:2001** Ачих, буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага |
| **Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал** | | | | | **750.00 мян.төг** | | | |

## *12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

### 12.1.Ерөнхий зүйл:

- UCS 1701A Хог хаягдалыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент, UCS 141B Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага стандартуудыг чанд баримтлан ажиллах
- Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12, 9.5.1, 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалтын дагуу ойр орчмын 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газарт нийтийн хамарсан их цэвэрлэгээ тогтмол хийх

### 12.2.Барилгын хог хаягдал

Хог хаягдлыг зориулалтын цэгээс нэгдсэн хогийг тээвэрлэхэд “MNS 5344:2011”, Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал, Ерөнхий шаардлага” стандартыг баримтлан ажиллана.

### 12.3.Хог хаягдлыг зайлуулах арга зам

Баянзүрх дүүргийн хот тохижилт үйлчилгээний газартай “Хог хаягдалын үйлчилгээний хураамжийг хураах, тээвэлэх гэрээ”–г байгуулан төвлөрсөн байдлаар ажиллана.

**Хүснэгт 10.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө**

| # | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | UCS 1701A Хог хаягдалыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент, UCS 141B Хашаа, хайс, хашлагад тавих ерөнхий шаардлага стандартуудыг чанд баримтлан ажиллах | Үйл ажиллагаа явуулахад орчны нөлөөллөөс хамгаалах | Төслийн талбайд | ** | 100.0 | 2026 он | **-УБ хотын UCS стандартууд**<br>-Хог хаягдалын тухай хууль<br>-БОАЖ-ын сайдын А/433 тогтоол “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах журам”<br>**“MNS 5344:2011** Ахуйн хог |
| 2 | Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12, 9.5.1, 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалтын дагуу ойр орчмын 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газарт нийтийн хамарсан их цэвэрлэгээ тогтмол хийх | 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газарт нийтийн хамарсан их цэвэрлэгээ тогтмол хийх | Төслийн талбайд | ** | 100.0 | 2026 он | |
| 3 | Баянзүрх дүүргийн ТҮГ-тай хог хаягдлыг тээвэрлэх гэрээ байгуулж цугларсан хог хаягдлыг хог хаягдлын нэгдсэн цэгт тээвэрлэн хүргэх ажлыг гүйцэтгэх | Төслийн хог хаягдалд зориулсан түр зуурын хадгалалтын бүс | 7 хоногт 2 удаа | ** | ** | 2026 он | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Хог хаягдлыг шатаахыг хориглох | Барилга барих ажлын талбайд | | | | | | хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага” “Засгийн газрын А/349 тогтоол Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт” “БОАЖ, Сангийн сайдын 192, А/243 хамтарсан тушаал Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох” |
| 5 | Хог хаягдал хуримтлуулах цэгт эрүүл ахуйн ариутгалыг тогтмол хийх | Барилга барих ажлын талбайд | тогтмол | ** | 50.0 | 2026 он | | |
| 6 | Хог хаягдлыг замбараагүй хаях, зөвшөөрөлгүй газарт хураах, цуглуулахыг хатуу хориглох | Барилга барих ажлын талбайд | тогтмол | ** | ** | 2026 он | | |
| 7 | Тааламжгүй үнэрийг үүсгэдэг материалуудыг тусгай саванд хадгалж, тээвэрлэх | Барилга барих ажлын талбайд | тогтмол | ** | ** | 2026 он | | |
| 8 | Шаардлагатай газруудад хатуу хог хаягдлыг түр ангилан хадгалах зориулалтын зөөврийн савнууд байрлуулах | Ажлын талбар хэсгүүд | тогтмол | ** | 150.0 | 2026 он | | |
| 9 | Тээврийн хэрэгслийн жолооч нарыг хогийн уутаар хангах | Бүх тээврийн хэрэгсэл | тогтмол | ** | 150.0 | 2026 он | | |
| 10 | Төслийн талбай болон түүний гаднах 10 метрийн бүсийг байнга цэвэрлэх бөгөөд хогийг тогтоогдсон цэгт хүргэж хаях. | Төслийн эдэлбэр газар болон түүний гадна 10 метрийн бүс | тогтмол | ** | ** | 2026 он | | |
| 11 | Хог хаягдлын менежмент, талбайн үзлэгийг өдөр тутамд зохион байгуулж хяналт тавих | Дулааны шугам талбай, хог хаягдал түр цуглуулах цэгүүд, гаднах 10 метрийн бүс | тогтмол | ** | ** | 2026 он | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | **Барилгын хог хаягдал:**<br>-Хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах хэрэгцээ үзүүлэлтээр нь ангилан ялгана.<br>-Барилга барихаас үүссэн дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг зайлуулах зөвшөөрлийг Баянзүрх дүүргийн Засаг даргаас авч, хог хаягдлын зөвшөөрөгдсөн цэгт тээвэрлэн зайлуулна.<br>-Хог хаягдлыг зөвшөөрөлгүйгээр зайлуулахыг хориглох<br>-Ажил дууссаны дараа гарсан хог хаягдлыг бүрэн цэвэрлэж заавал зайлуулна, талбайг чөлөөлнө.<br>-Хаягдал шороон материалыг их хэмжээгээр хуримтлуулалгүйгээр тухай бүрт зайлуулж байх<br>-Гэрээт гүйцэтгэгч нь хаягдал шороон материалын ялгарал, овоолго, ачиж зайлуулсан тоо хэмжээний бүртгэлийг өдөр тутам хөтөлнө. | Барилга барих талбайд | тогтмол | ** | ** | 2026 он | -Хотын стандарт-2019. Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага<br>**-MNS BS 5906:2018**<br>Барилга доторх хог хаягдлын менежмент - Ашиглалтын дүрэм |
| 13 | **Аюултай хаягдал /машин механизмы ашигласан тос тосолгооны материал /:**<br>-Тос тослох материал асгарсан бол шингээх материал болон элс, бохирдсон хөрс зэргийг тусгай зөвшөөрөлтэй хог хаягдал зайлуулах талбайд хаях<br>-Аюултай хог хаягдлыг зүй ёсны лицензтэй /зөвшөөрөлтэй/ байгууламж руу дахин боловсруулах, дахин ашиглах, зайлуулах зорилгоор тээвэрлэх<br>-Аюултай хог хаягдлыг тээвэрлэхэд холбогдох хууль тогтоомжийг мөрдөх | Барилга барих талбайд | тогтмол | ** | 50.0 | 2026 он | "Аюултай хог хаягдалын жагсаалт"<br>"Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам" |
| **Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал** | | | **600.0 мян.төг** | | | | |

## 13.ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн 11-р хороонд хэрэгжих төслөөс байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нэг чухал баримт бичиг юм.

Тухайн төслийн хэрэгжүүлснээр үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг "орчны хяналт шинжилгээний хөтөлбөр" гэнэ.Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ -н харъяа БОХЗТЛ -ийн үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу төсөл хэрэгжүүлэгч нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Нийслэлийн байгаль орчны газарт /-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт "Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана." хэмээн "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 1.6-д заасан байна. Үүний дагуу бид байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

### 13.1.Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардал

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч нь хариуцах болно.

### Хүснэгт 11.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

| д/д | Хяналт үзүүлэлт | Байршил, цэгийн тоо | Давтамж | Хууль, бодлого, стандарт | Хариуцах эзэн | Хамтран хэрэгүүлэгч | Биелэл-тийн шалгуур | Нэгж зардал, мян.төг | Нийт зардал, мян.төг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Агаар орчин** | | | | | | | | | |
| **Агаар орчин** | Тоос-TSP, PM10, PM2.5 Бохирдуулагч хий-$SO_2$, CO, $NO_2$ | 2 цэгт | Жилд 1 удаа | **MNS 5885:2008** **MNS 4585:2025** **MNS 6768:2019** Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага | "Ланд энд хаус" ХХК | БОХТЛ | Хяналт, монито-ринг сайжирна | 50.0 | 50.0 |
| | Орчны агаар дахь дуу шуугиан ба чичирхийллийн түвшин | Төслийн талбайн идэвхтэй 2 цэгт | Жилд 1 удаа | | "Ланд энд хаус" ХХК | БОХТЛ | Хяналт, монито-ринг сайжирна | 50.0 | 50.0 |
| | Тоног төхөөрөмж ба машин механизмын дуу шуугиан ялгаруулах түвшин | Бүх тээврийн хэрэгсэл | 9,10-р сарын эхний 10 хоногт | | "Ланд энд хаус" ХХК | БОМТ-д тусгах | БОМТ-д тусгах | ** | ** |
| **Хөрсөн бүрхэвч** | | | | | | | | | |
| **Хөрс бохирдох** | Хөрсний төлөв, элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, pH, давсжилт, чийгшилт, физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, $P_2O_5$, $K_2O$, хүнд металлын үзүүлэлтүүд / | Барилгын талбайд нийт 2 цэгт | Жилд 1 удаа | **MNS 3298:1991** Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд. | "Ланд энд хаус" ХХК | ГЗГЭХ-ийн Хөрс судлалын лаборатори; БОХТЛ; | Хяналт, монито-ринг сайжирна | 50.0 | 50.0 |
| | Хөрсний микробиологийн шинжилгээ, хүнд металл 6 элемент | Барилга баригдах ажлын талбай | Жилд 1 удаа | **MNS 3297:2019** Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх | "Ланд энд хаус" ХХК | ГЗГЭХ-ийн Хөрс судлалын лаборатори; БОХТЛ; | Хяналт, монито-ринг сайжирна | 50.0 | 50.0 |
| **Эрүүл ахуйн хяналт шинжилгээ** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хог хаягдлын цэг, ажилчдын 00, амрах байр, ажлын орчин нөхцөлд хяналт хийх | Барилгын ажлын талбай, хог хаягдал цуглуулах цэг, ариун цэврийн байгууламж | Барилгын ажлын талбай, хог хаягдал цуглуулах цэг, ариун цэврийн байгууламж | ** | **MNS 4968:2026** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага | "Ланд энд хаус" ХХК | "Нарт шуүн консалтинг" лаборатори | Хяналт, монито-ринг сайжирна | 50.0 | 50.0 |
| **Ус орчин** | | | | | | | | | |
| Усан орчин бохирдох | Ерөнхий хими | 1.Худгийн ус | Жилд нэг удаа | 1.Усны чанар эрүүл ахуйн стандарт MNS 900-2018 | Төсөл хэрэгжүү-лэгч | Монгол ус Төрийн өмчит үйлдвэрийн газар | Шинжилгээний дүн | 50.0 | 500.0 |
| Орчны хяналт шинжилгээний зардлын нийт дүн: | | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 сард багтаан Нийслэлийн Байгаль Орчны Газарт тайлагнах нь зүйтэй | | | | | | 300.0 мян.төг | |

## 14.2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын асуудал ихээхэн чухал үүрэгтэй юм. Удирдлага зохион байгуулалтын менежментийг дараах чиглэлд хандуулан төлөвлөгөөндөө тусгах нь зүйтэй.

- Эдгээр ажлуудыг хариуцан гүйцэтгэх байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах
- Байгаль орчны асуудал хариуцаж ажиллах ажилтан албан хаагч, түүний үүрэг хариуцлага Байгаль орчны чиглэлээр орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлын чиглэл
- Ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулах сургалт, танилцуулгын ажил, мэдээллийн самбар
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдэх ажил
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх хяналт, шалгалтын хуваарь, бүртгэл хөтлөх, түүнийг хариуцах үүрэг хариуцлагын систем
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, хуваарь
- Байгаль орчин хамгааллын чиглэлээр хийгдэх ажлын төсөв санхүүгийн зохицуулалт

**Хүснэгт 12.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

| Авч хэрэгжүүлэх арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт зардал мян.төг | Хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч | Биелэлтийн шалгуур | Баримтлах стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тухайн жилийн БОМТ-г боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг тайлагнах | Төслийн үйл ажиллагаа | удаа | 1 | ** | "Ланд энд хаус" ХХК | Мэргэжлийн байгууллага | БОМТ батлагдсан, хэлэлцүүлэг хийгдсэн, тайлагнасан байна | БОАЖ-ын сайдын 2019.10.29-ны өдрийн А/618 |
| - Байгаль орчин хамгаалах<br>-Гал түймрээс урьдчилан сэргийлэх<br>- Хөдөлмөр хамгаалал зэрэг сэдвээр сургалт, сурталчилгаа зохион | Бүх ажилтан | удаа | 1 | 200.0 | "Ланд энд хаус" ХХК | Мэргэжлийн байгууллага | Сургалтанд хамрагдсан бүртгэл тэмдэглэл | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, стандартууд |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| байгуулах | | | | | | | | |
| Төсөл хэрэгжүүлэгчийн зардлаар Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын тухай хууль, журам, стандартын биелэлтэд дотоод хяналтыг зохион байгуулах | Төслийн талбайд | удаа | 5 | ** | "Ланд энд хаус" ХХК | Мэргэжлийн байгууллага | Шалгалтын үр дүнг илтгэсэн тайлан | БОХ тухай хууль |
| Жил бүрийн 12 сар дотор дараа онд хэрэгжүүлэх БОМТөлөвлөгөөг боловсруулж, Нийслэлийн Байгаль Орчны Газраар хянуулж, баталгаажуулах, биелэлтийг тухайн жилийн БОМТөлөвлөгөө хамрагдах оны 11 сарын 01-ны дотор Нийслэлийн Байгаль Орчны Газраар дүгнүүлэх | Жил бүр | удаа | 1 | 150.0 | | БОМТ-ийн биелэлт дүгнүүлэх бүрэлдэхүүн:<br>- Нийслэлийн МХГ-ын БОХУ-ын байцаагч<br>- Газрын даамал<br>- Сав газрын захиргааны мэргэжилтэн<br>- Дүүргийн БОХУ-ын байцаагч<br>-Байгаль хамгаалагч<br>-Нөлөөллийн бүсэд оршин суугаа иргэн оролцох | БОМТ-ний биелэлтийн 90%-иас дээш байх | БОАЖ-ын сайдын 2019.10.29-ны өдрийн А/618 |
| Нийт дүн мян.төг | | | | **350.0 мян.төг** | | | | |

## *15.2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ*

**Хүснэгт 13.Оролцогч талуудад тайлагнах хуваарь**

| № | Төлөвлөгөөний хэрэгжилтийг хаана тайлагнах болон хэлэлцүүлэх | Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр | Зардал мян.төг | Мэдээллийн агуулга | Хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дүүргийн иргэдэд БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах | Тайлагнах | 100.0 | Жил бүрийн БОМТ-ний хэрэгжилт үр дүнгийн тайлан | Жил бүр |
| 2. | Нийслэлийн Байгаль Орчны газарт БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах | Тайлагнах | 100.0 | Жил бүрийн БОМТ-ний хэрэгжилт үр дүнгийн тайлан /биелэлтийн тайланг дүгнүүлэх/ | Жил бүрийн 11.01 |
| 3. | Нийслэлийн Байгаль Орчны газарт | Батлуулах | 100.0 | БОМТ-г батлуулах | Жил бүрийн 12.01 |
| **Оролцогч талуудад тайлагнах зардал** | | | **300.0** | | |

Энэхүү "Ланд энд хаус" ХХК-ийн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Аялал жуулчлалын цогцолбор хотхон" төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2019 оны 10-р сарын 29-ний өдөр шинэчлэгдэн батлагдсан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах тайлагнах журмыг удирдлага болгон ажиллав.

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, Хянан батлах, тайлагнах журмын дагуу тухайн жилийн БОМТ-г боловсруулж батлуулах ба БОМТ-ний биелэлтийг тайлагнах үүргийг хүлээнэ.

**Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөөний НИЙТ ЗАРДАЛД 5750.0 МЯНГАН (ТАВАН САЯ ДОЛООН ЗУУН ТАВИН МЯНГА) төгрөг төлөвлөлөө.**